ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/013/НА-СТА-ТТЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2026 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.03.24 № 01/249

танай ______________-ны № ____________________-т

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
ЗАСАГ ДАРГА А.МӨНГӨНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, “Зөв бодлого-оновчтой шийдэл-тогтвортой хөгжлийг хангаан иргэд үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамж, стандартын шаардлагад нийцсэн нийгэм эдийн засгийн эрчимтэй өсөлтийг эрхэмлэнэ” гэсэн зорилт тавин ажиллажээ.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн Газрын 161 дүгээр тогтоолоор “Сумын хөгжил инженерийн дэд бүтцийн хангамж” I шатны төслийн хүрээнд 4.5 тэрбум төгрөгөөр, II үе шатанд 1.7 тэрбум төгрөгөөр дулаан, цахилгаан цэвэр, бохир усны шугамд төсвийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг холбох ажил хийгдсэн байна.

Төв аймгийн Эрдэнэ суманд тайлант онд 6,700,000.0 мянган төгрөгийн өртөгтэй Англи хэлний сургалтын төвийн барилга ашиглалтад орсноор “Jolly campus” Англи

4126020605

хэлний академиас боловсролыг дэмжих зорилгоор “Бизнесийн англи хэлний суурь шатны практик сургалт” зохион байгуулахад төрийн албан хаагч болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд хамрагдсанаар оюуны хөрөнгө оруулалт хийсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 19-ний 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 104 зорилт 161 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 96,6%-тай буюу “Үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,532,768.02** | **2,967,069.54** |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 554,817.33 | 1,689,906.33 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 385,407.39 | 620,969.74 |
| 4 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 592,543.29 | 656,193.46 |
| **5** | **1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,206,416.84** | **8,544,656.7** |
| 6 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,206,416.84 | 8,544,656.7 |
| 7 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 5,275,169.25 | 5,613,469.71 |
| 8 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 2,931,247.6 | 2,931,187 |
| **9** | **1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **9,739,184.86** | **11,511,726.25** |
| 10 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | 33,708.52 | 67,313.05 |
| 11 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 33,708.52 | 67,313.05 |
| 12 | 2.1.1.03 Өглөг | 33,708.52 | 67,313.05 |
| **13** | **2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,705,476.34** | **11,444,413.2** |
| 14 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 9,705,476.34 | 11,444,413.2 |
| 15 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 533,911.87 | 533,911.87 |
| 16 | 2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 100 | 100 |
| 17 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 9,026,697.05 | 10,765,633.91 |
| 18 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 144,767.42 | 144,767.42 |
| **19** | **2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **9,739,184.86** | **11,511,726.25** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **8,875,682.87** | **4,746,766.16** |
| **2** | **1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО** | **2,222,471.69** | **2,474,216.06** |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | 1,164,280.25 | 1,399,486.97 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 1,164,280.25 | 1,399,486.97 |
| 5 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 181,326.3 | 242,679.33 |
| 6 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 876,865.14 | 832,049.77 |
| **7** | **1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,625,607.88** | **2,272,550.1** |
| 8 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | 250,979.4 | 382,845.81 |
| **9** | **1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,027,603.31** | **0** |
| **10** | **1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,072,557.66** | **2,948,029.69** |
| **11** | **1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,072,557.66** | **2,948,029.69** |
| **12** | **1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,012,190.98** | **2,916,368.49** |
| 13 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 760,753.78 | 941,224.29 |
| 14 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,453.31 | 124,063.24 |
| 15 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 920,691.93 | 932,356.08 |
| 16 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 111,744.06 | 88,751.56 |
| 17 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 32,636.05 | 43,738 |
| 18 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 13,710 | 21,947.5 |
| 19 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 53,578.39 | 61,478.44 |
| 20 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,021,623.47 | 702,809.37 |
| **21** | **1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **60,366.68** | **31,661.2** |
| **22** | **1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **5,803,125.2** | **1,798,736.48** |
| **23** | **1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **1,324,946.78** | **59,799.61** |
| **24** | **1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **-1,324,946.78** | **-59,799.61** |
| **25** | **1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **4,478,178.42** | **1,738,936.86** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон / мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **5,238,097.10** | **4,589,760.50** |
| **2** | **1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО** | **2,222,471.69** | **2,474,216.06** |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 1,164,280.25 | 1,399,486.97 |
| 4 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 181,326.3 | 242,679.33 |
| 5 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 876,865.14 | 832,049.77 |
| 6 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 59,128.96 | 62,724.39 |
| 7 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 728,001.65 | 701,195.26 |
| 8 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 89,734.53 | 68,130.12 |
| **9** | **1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **971,022.11** | **2,115,544.44** |
| 10 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 720,042.71 | 959,786.33 |
| 11 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 250,979.4 | 382,845.81 |
| 12 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0 | 772,912.3 |
| **13** | **1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,044,603.31** | **0** |
| **14** | **1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,478,208.31** | **2,556,409.16** |
| **15** | **1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,478,208.31** | **2,556,409.16** |
| **16** | **1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,417,841.63** | **2,524,747.96** |
| 17 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 760,753.78 | 941,224.29 |
| 18 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 100,490.38 | 123,330.57 |
| 19 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 920,843.93 | 932,680.08 |
| 20 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 294,170.83 | 248,583.13 |
| 21 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 33,027.73 | 43,738 |
| 22 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 13,710 | 19,057.5 |
| 23 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 97,911.86 | 64,170.23 |
| 24 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 196,933.13 | 151,964.17 |
| **25** | **1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **60,366.68** | **31,661.2** |
| **26** | **1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,759,888.8** | **2,033,351.34** |
| **27** | **1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **3,142,420.53** | **747,010.84** |
| **28** | **1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,142,420.53** | **747,010.84** |
| 29 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 3,142,420.53 | 747,010.84 |
| **30** | **1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-3,142,420.53** | **-747,010.84** |
| **31** | **1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **50,182** | **151,251.5** |
| **32** | **1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-50,182** | **-151,251.5** |
| **33** | **1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-432,713.74** | **1,135,089** |
| 34 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 987,531.07 | 554,817.33 |
| 35 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 554,817.33 | 1,689,906.33 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,227,297.92** | **5,227,297.92** |
| 2 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,227,297.92 | 5,227,297.92 |
| 3 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 4,478,178.42 | 4,478,178.42 |
| **4** | **1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **9,705,476.34** | **9,705,476.34** |
| **5** | **1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **9,705,476.34** | **9,705,476.34** |
| 6 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 9,705,476.34 | 9,705,476.34 |
| 7 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 1,738,936.86 | 1,738,936.86 |
| **8** | **1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **11,444,413.2** | **11,444,413.2** |

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| № | Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | **1** | **3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **6,182,534.50** | **6,567,359.61** | **(384,825.11)** | **106.2** |
| **2** | **11** | **3.1.01.1.1 Татварын орлого** | **2,008,421.70** | **2,474,216.06** | **(465,794.36)** | **123.2** |
| **3** | **110** | **3.1.01.1.1.1 Орлогын албан татвар** | **1,150,890.00** | **1,399,486.97** | **(248,596.97)** | **121.6** |
| **4** | 1100 | 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 1,150,890.00 | 1,399,486.97 | (248,596.97) | 121.6 |
| **5** | 113 | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 154,232.50 | 242,679.33 | (88,446.83) | 157.3 |
| **6** | 118 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 703,299.20 | 832,049.77 | (128,750.57) | 118.3 |
| **7** | 1180 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 45,000.00 | 62,724.39 | (17,724.39) | 139.4 |
| **8** | 1181 | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 552,299.20 | 701,195.26 | (148,896.06) | 127.0 |
| **9** | 1182 | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 106,000.00 | 68,130.12 | 37,869.88 | 64.3 |
| **10** | **12** | **3.1.01.1.2 Татварын бус орлого** | **4,174,112.80** | **4,093,143.55** | **80,969.25** | **98.1** |
| **11** | 120 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 369,000.00 | 792,931.36 | (423,931.36) | 214.9 |
| **12** | 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 3,026,540.60 | 2,527,299.90 | 499,240.70 | 83.5 |
| **13** | 123 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 778,572.20 | 772,912.30 | 5,659.90 | 99.3 |
| **14** | **II** | **3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,506,193.80** | **3,085,340.52** | **420,853.28** | **88.0** |
| **15** | **21** | **3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,417,889.30** | **2,214,001.18** | **203,888.12** | **91.6** |
| **16** | **210** | **3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,378,574.30** | **2,185,039.98** | **193,534.32** | **91.9** |
| **17** | 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 871,305.60 | 829,922.94 | 41,382.66 | 95.3 |
| **18** | 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 112,729.20 | 110,652.94 | 2,076.26 | 98.2 |
| **19** | 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 939,122.80 | 932,356.08 | 6,766.72 | 99.3 |
| **20** | 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 109,064.40 | 84,478.84 | 24,585.56 | 77.5 |
| **21** | 2105 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 1,190.00 | - | 1,190.00 | 0.0 |
| **22** | 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 74,000.00 | 67,833.00 | 6,167.00 | 91.7 |
| **23** | 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 23,810.00 | 19,057.50 | 4,752.50 | 80.0 |
| **24** | 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 87,360.30 | 50,604.51 | 36,755.79 | 57.9 |
| **25** | 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 159,992.00 | 90,134.17 | 69,857.84 | 56.3 |
| **26** | **213** | **3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,315.00** | **28,961.20** | **10,353.80** | **73.7** |
| **27** | **2132** | **3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг** | **39,315.00** | **28,961.20** | **10,353.80** | 73.7 |
| **28** | **22** | **3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **936,304.50** | **720,087.84** | **216,216.66** | 76.9 |
| **29** | **23** | **3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **152,000.00** | **151,251.50** | **748.5** | **99.5** |
| **30** | 4 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 481054180 | | |
| **31** | 5 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 1652510873 | | |
| **32** | 6 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 66 | 66 | | 100 |
| **33** | 61 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 | | 100 |
| **34** | 62 | 6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО | 32 | 32 | | 100 |
| **35** | 65 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 32 | 32 | | 100 |

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

| № | Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **1** | **1** | **1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **770,369.11** | **166,108.31** |
| **2** | **II** | **1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **770,369.11** | **151,973.44** |
| **3** | **21** | **1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ** | **244,048.24** | **151,973.44** |
| **4** | **210** | **1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **164,351.93** | **149,273.44** |
| 5 | 2101 | 1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 65,359.75 | 104,710.12 |
| 6 | 2102 | 1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 7,309.86 | 12,677.63 |
| 7 | 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 5,077.61 | 1,405.70 |
| 8 | 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 510.00 | |
| 9 | 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,356.64 | |
| 10 | 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 83,738.08 | 30,480.00 |
| **11** | **213** | **1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **79,696.30** | **2,700.00** |
| **12** | **22** | **3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **526,320.87** | |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитаар нийт 165,462.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

**Залруулсан алдаа:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн татварын болон татварын бус орлого тодотгон батлагдсан төлөвлөгөөнөөс 5 нэр төрлийн орлого 165,462.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.4-д “төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажилла” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нийт алдаа, зөрчлөөс урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 52,592.9 мянган төгрөгөөс бага буюу материаллаг алдаа илрээгүй тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

**5.2 Зөвлөмж**

1.Шилэн данстай холбоотой асуудал:

Тайлант онд Засаг дарга шилэн дансанд 132 мэдээлэл хугацаа хоцроож, хугацаа хоцролтын хэрэгжилт 73,5% байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | | 1 | | | | | |
| 2 | Засаг даргын тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 3 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Эмийн эргэлтийн сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | **5** | **1** | **4** | | **1** | | | |

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

**/мянган төгрөгөөр/**

| **Байгууллагын нэр** | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 1 | 505,180.4 | | | 1 | 505,180.4 | 1 | 505,180.4 | | |
| Соёлын төв | 1 | 9,981.7 | | | 1 | 9,981.7 | 1 | 9,981.7 | | |
| ОНХС | 1 | 7,129.8 | 1 | 7,129.8 | | | 1 | 7,129.8 | | |
| Дүн | **3** | **522,291.8** | **1** | **7,129.8** | **2** | **515,162.0** | **2** | **522,291.8** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ИТХ | 1 | 14,700.0 | | | 1 | 14,700.0 | | |
| ЗДТГ | 4 | 113,929.5 | | | | | 4 | 113,929.5 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 87,865.4 | | | | | 1 | 87,865.4 |
| Соёлын төв | 2 | 1,858.3 | | | | | 2 | 1,858.3 |
| **Дүн** | **8** | **218,353.2** | | | **1** | **14,700.0** | **7** | **203,653.2** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ИТХ | 1 | | | | | | 1 | |
| Соёлын төв | 1 | | | | | | 1 | |
| ЭЭС | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | **3** | | | | | | **3** | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn